

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн ..... дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

**МОНГОЛБАНКНЫ ГАДААД ВАЛЮТЫН  
СПОТ АРИЛЖААНЫ ЖУРАМ**  
(төсөл)

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэ журмын зорилго нь гадаад валютын дотоодын захын тогтвортой байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүү, түүнээс үүдэлтэй ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор Монголбанкнаас гадаад валютын дотоод захад оролцох үйл ажиллагаанд баримтлах зарчим, шийдвэр гаргах үйл явц, үйл ажиллагааны дарааллыг тодорхойлох, түүнд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

**ХОЁР. ҮНДСЭН ЗАРЧИМ**

2.1. Монголбанкны гадаад валютын спот арилжааны хэмжээ, ханш, оролцооны хэлбэрийг “Шуурхай зөвлөл”-ийн хурлаар шийдвэрлэх бөгөөд Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан нэгж гадаад валютын арилжааг зохион байгуулна.

2.2. Шуурхай зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.

**ГУРАВ. АРИЛЖААНЫ ХЭЛБЭР**

3.1 Монголбанк спот арилжааг дараах хэлбэрээр зохион байгуулна.

3.1.1 Дуудлага худалдаа зохион байгуулах;

3.1.2 Цахим талбараар оролцох;

3.1.3 Банкаар дамжуулан харилцагчийн захиалгыг биелүүлэх.

3.2 Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан нэгж нь холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд төрийн байгууллага, Монголбанкинд данстай олон улсын байгууллага болон бусад байгууллагатай гадаад валютын арилжаа хийж болно.

**ДӨРӨВ. ДУУДЛАГА ХУДАЛДАА**

4.1 Дуудлага худалдааны хуваарьт өдөр, валют, дуудлага худалдаанд ирүүлэх нийт саналын тоо, нэгж саналын дээд, доод валютын хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална

4.2 Дуудлага худалдааны хуваарьт өдөр олон нийтээр амрах өдөр тохиовол дуудлага худалдааг өмнөх ажлын өдөр зохион байгуулна.

4.3 Шаардлагатай тохиолдолд дуудлага худалдааг цуцлах, энэ журмын 4.1-д зааснаас өөр өдөр зохион байгуулж болно. Энэ тохиолдолд банкуудад цахим шуудангаар эсвэл утсаар шуурхай мэдэгдэнэ.

4.4 Дуудлага худалдаанд Монгол Улсын Хөгжлийн Банкнаас бусад банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй банк оролцоно.

4.5 Дуудлага худалдаа нь “ялгаатай ханшаар хийх арилжаа”, “нэг ханшаар хийх арилжааны хэлбэртэй байна.

4.6 “Ялгаатай ханшаар хийх арилжаа” нь амжилттай биелсэн банкуудын саналыг тухайн саналын ханшаар, “Нэг ханшаар хийх арилжаа” нь амжилттай биелсэн банкуудын бүх саналыг хаалтын нэг ханшаар биелүүлнэ.

4.7 Тухайн дуудлага худалдаанд биелсэн худалдах саналын хамгийн их ханшийг, худалдан авах саналын хамгийн бага ханшийг хаалтын ханшаар тооцно.

4.8 Монголбанк дараах тохиолдолд дуудлага худалдаанд оролцох саналыг цуцлах эрхтэй:

4.8.1 Гадаад валютын зохистой харьцааны тайланг өөрчлөлтийн тайлбарын хамт дуудлага худалдаа болохоос ажлын нэг өдрийн өмнөх байдлаар гарган Монголбанкинд дуудлага худалдаа болох өдөр 10:00 цагаас өмнө ирүүлээгүй банкны бүх саналыг;

4.8.2 Банкны ирүүлсэн саналын ханш нь зах зээлийн ханшаас хэт зөрүүтэй, хуйвалдсан эсхүл шударга бус;

4.8.3 Банкны ирүүлсэн саналын захиалга нь валютын захад бодит бус эрэлт үүсгэж буй шинж чанартай;

4.8.4 Банкны ирүүлсэн санал биелсэн тохиолдолд гадаад валютын эрсдэлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг зөрчих эрсдэлтэй;

4.8.5 Банкны ирүүлсэн харилцагчийн захиалгын биелэлт хангалтгүй хэмээн үзсэн нөхцөлд Монголбанк саналыг цуцалж болно.

4.9 Дуудлага худалдааны санал авах үйл ажиллагаа тухайн өдрийн 09:30 цагт эхэлж 10:00 цагт дуусах бөгөөд энэ журмын 4.2-т заасны дагуу санал авах үйл ажиллагааны цагийн хуваарь өөр байж болно.

4.10 Дуудлага худалдаагаар банкны худалдан авах саналыг дараах байдлаар тодорхойлно:

4.10.1 Баталгаажсан бүх саналыг хамгийн өндөр худалдан авах ханшаас эхлэн хамгийн бага ханш хүртэл эрэмбэлнэ.

4.10.2 Дуудлага худалдаагаар худалдах гадаад валютын хэмжээг дуусгавар болох хүртэл баталгаажсан саналыг хамгийн өндөр худалдан авах ханшаас эхлэн биелүүлнэ. Хэрэв тухайн өдөр дуудлага худалдаагаар Монголбанкны худалдах гадаад валютын дүнгээс биелэх саналын нийлбэр дүн нь хэтэрсэн тохиолдолд хамгийн бага биелэгдэх ханш дээр ирсэн санал бүрийг нийт уг ханш дээр ирүүлсэн саналд харьцуулж тооцсон харьцаагаар энэ ханш дээр Монголбанкны худалдах гадаад валютын хэмжээнд үржүүлэн гадаад валютыг хуваарилна.

4.11 Дуудлага худалдаагаар банкны худалдах саналыг дараах байдлаар тодорхойлно:

- 4.11.1 Баталгаажсан бүх саналыг хамгийн бага худалдах ханшаас эхлэн хамгийн өндөр ханш хүртэл эрэмбэлнэ.
- 4.11.2 Дуудлага худалдаагаар худалдан авах гадаад валютын хэмжээг дуусгавар болох хүртэл баталгаажсан саналыг хамгийн бага худалдах ханшаас эхлэн биелүүлнэ. Хэрэв тухайн өдөр дуудлага худалдаагаар худалдах гадаад валютын дүнгээс биелэгдэх саналын нийлбэр дүн нь хэтэрсэн тохиолдолд хамгийн өндөр биелэгдэх ханш дээр ирсэн санал бүрийг нийт уг ханш дээр ирүүлсэн саналд харьцуулж тооцсон харьцаагаар энэ ханш дээр Монголбанкны худалдан авах гадаад валютын хэмжээнд үржүүлэн саналыг биелүүлнэ.
- 4.12 Давагдашгүй хүчин зүйл болон цахим арилжааны сүлжээнд эвдрэл гарсны улмаас дуудлага худалдааны санал авах үйл ажиллагаа тухайн өдрийн 09:30 цагт эхлэх боломжгүй бол дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 4.12.1 Монголбанк арилжаа хийх хугацааг сунгаж болно. Ингэхдээ банкуудад цахим шуудан, цахим талбараар зурвас илгээх эсвэл утсаар мэдэгдэнэ.
- 4.12.2 Цахим талбарын сүлжээнд гарсан эвдрэлийг засах боломжгүй бол энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу банкуудаас гадаад валютын худалдах, худалдан авах саналыг цахим шуудангаар эсвэл факсаар хүлээн авах бөгөөд уг саналыг албан бичгээр нөхөж авна. Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газрын эдийн засагч банкны саналын битүүмж, лацыг шалгаж, банкны ажилтантай энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу баримт үйлдэнэ.
- 4.13 Энэ журмын 4.12-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газрын ахлах эдийн засагч, эдийн засагч нар банкуудын саналыг 10:00 цагт эсвэл сунгасан хугацааг дуусгавар болмогц нэгтгэнэ.
- 4.14 Дуудлага худалдааны үр дүнгийн талаарх мэдээллийг тухайн өдөрт багтаан Монголбанкны цахим хуудсанд нийтэлж болно.

## **ТАВ. ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖАА**

- 5.1 Монголбанк гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүү, түүнээс үүдэлтэй ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор дараах хэлбэрээр цахим талбарын арилжаанд оролцоно:
- 5.1.1. Үндсэн дилерээр дамжуулан оролцох;
- 5.1.2. Цахим талбарын арилжаанд идэвхтэй саналыг биелүүлэх;
- 5.1.3. Цахим талбарт санал оруулах.
- 5.2 Энэ журмын 5.1.1, 5.1.2-т заасан арилжаанд оролцоходоо дараах хүчин зүйлсийг харгалзана:
- 5.3.1. Гадаад валютын дотоодын захын нөхцөл байдал;
- 5.3.2. Гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүү;
- 5.3.3. Банкны гадаад валютын арилжааны гүйцэтгэл, харилцагчдаа худалдсан, худалдан авсан валютын хэмжээ;

- 5.3.4. Банкны харилцагчийн захиалга нь валютын захад бодит бус эрэлт үүсгэж буй шинж чанартай эсэх;
- 5.3.5. Банкны нээлттэй позицийн хэмжээ, өөрчлөлтийн шалтгаан.
- 5.3 Энэ журмын 5.1.1-д заасан арилжаанд оролцох зарчим, холбогдох үйл ажиллагааг гэрээгээр зохицуулна.
- 5.4 Монголбанк цахим талбарт валют худалдахад банкны тухайн өдрийн цахим талбарын арилжааны хязгаарыг тооцохгүй болно.
- 5.5 Монголбанкнаас цахим талбарт оролцсон тухай мэдээллийг олон нийтэд мэдээлж болно.

### **ЗУРГАА. БАНКААР ДАМЖУУЛАН ХАРИЛЦАГЧИЙН ЗАХИАЛГЫГ БИЕЛҮҮЛЭХ**

- 6.1. Монголбанк нь дараах нөхцөл байдлыг харгалзан үзэж банкаар дамжуулан харилцагчийн захиалгыг биелүүлэх хэлбэрээр арилжаанд оролцож болно:
- 6.1.1. Төгрөгийн ханшийн өдрийн огцом хэлбэлзэл;
- 6.1.2. Хөрвөх чадварын хомсдол, их хэмжээний валютын нийлүүлэлт үүсэх эсвэл өндөр дүнтэй төлбөрийг богино хугацаанд гаргаж чадахгүй болох;
- 6.1.3. Бусад шалтгаан.
- 6.2. Энэ журмын 6.1-д заасан арилжааг үндсэн дилерээр дамжуулан гүйцэтгэнэ.
- 6.3. Монголбанкнаас банкаар дамжуулан харилцагчийн захиалгыг биелүүлэх зарчим, холбогдох үйл ажиллагааг гэрээгээр зохицуулна.
- 6.4. Монголбанкнаас банкаар дамжуулан харилцагчийн захиалгыг биелүүлэх арилжааны үр дүнгийн талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрлийн дагуу олон нийтэд мэдээлж болно.

### **ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО**

- 7.1 Монголбанкны Тайлан бүртгэл хариуцсан нэгж нь энэ журмын 3.1-д заасан арилжааны төлбөр тооцоог Монголбанкны Ерөнхийлөгчийн холбогдох тушаалын дагуу төлбөр тооцооны өдөр хийж гүйцэтгэнэ.
- 7.2 Энэ журмын 3.1-д заасан арилжааны гүйлгээг дамжуулах үед банкны Монголбанкин дахь харилцах дансны үлдэгдэл хүрэлцээгүй тохиолдолд саатсан гүйлгээнд тооцно.
- 7.3 Банк саатсан гүйлгээний төлбөр тооцоог тухайн өдрийн 16:30 цагаас өмнө гүйцэтгээгүй тохиолдолд Монголбанкны Тайлан бүртгэл хариуцсан нэгжээс гүйлгээг цуцалж, тус арилжааг цуцлагдсанд тооцно.
- 7.4 Энэ журмын 3.1-д заасан арилжааны гүйлгээ болон энэ журмын 7.3-д заасан цуцлагдсан арилжаанд тооцогдох гүйлгээ нь Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн системд автоматаар үүснэ.

### **НАЙМ. МОНГОЛБАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ**

8.1 Монголбанк нь тухайн гадаад валютын арилжаагаар оролцох хэмжээ, ханш, оролцооны хэлбэр, нөхцөл, давтамжийг тогтооно.

8.2 Монголбанк нь банкуудын гадаад валютын арилжаанд оролцох саналтай холбоотой мэдээ, мэдээлэл, тайлбарыг банкнаас гаргуулан авах эрхтэй бөгөөд тус мэдээллийг нууцална.

8.3 Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан нэгж нь арилжаа цуцалсан банкинд холбогдох гэрээний дагуу арга хэмжээг авна.

8.4 Энэ журмын 9.4-д заасан заалтыг зөрчсөнөөс үүдэн гарах аливаа хохирлыг Монголбанк хариуцахгүй болно.

8.5 Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газрын саналаар шаардлагатай тохиолдолд, эсвэл ээлжит хяналт шалгалтын хүрээнд Монголбанкны Хяналт шалгалт хариуцсан нэгж нь энэ журмын биелэлтэнд газар дээрх хяналт шалгалтыг хийж, зөрчил илэрсэн банкинд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

## **ЕС. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ**

9.1 Банк нь гадаад валют худалдах, худалдан авах саналаа нэгэнт баталгаажуулсан бол уг саналаас татгалзах, түүнийг буцаах, өөрчлөх эрхгүй.

9.2 Энэ журмын 4.12.2-д заасны дагуу дуудлага худалдаанд бичгээр ирүүлсэн санал нь банкны итгэмжлэгдсэн албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

9.3 Банк нь төлбөр тооцоо гүйцэтгэх үед Монголбанкин дахь харилцах дансандаа хангалттай хэмжээний мөнгөн хөрөнгө байршуулсан байна.

9.4 Банк нь аливаа систем, програмд нэвтрэх, арилжаа хийх хэрэглэгчийн эрх, түүний нууцлалыг хариуцна.

9.5 Банк нь харилцагчийн захиалгын дагуу гадаад валют худалдан авах санал Монголбанкинд ирүүлсэн тохиолдолд захиалгын хэрэгжилтийг арилжааны төлбөр тооцоо хийгдсэнээс ажлын хоёр өдрийн дотор цахим шуудангаар Монголбанкинд ирүүлнэ.

9.6 Банк нь хүлээгдэж буй валютын эрэлтийн мэдээг цахим хэлбэрээр [domex@mongolbank.mn](mailto:domex@mongolbank.mn) хаягаар болон цахим системд тогтмол ирүүлнэ.

## **АРАВ. ХАРИУЦЛАГА**

10.1 Энэ журмын аливаа заалтыг зөрчсөн банкинд Монголбанк дараах хариуцлагыг тооцно:

10.1.1. Энэ журмын аливаа заалтыг эхний удаа зөрчсөн тохиолдолд Монголбанкны улсын байцаагч банкинд мэдэгдэх хуудас хүргүүлж, “Банкны тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн дагуу мөнгөн торгууль ногдуулна. Ингэхдээ тухайн банкны Монголбанкин дахь харилцах данснаас үл маргах журмаар хасалт хийнэ.

10.1.2. Банк энэ журмын аливаа заалтыг давтан зөрчсөн тохиолдолд “Банкны тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн дагуу мөнгөн торгууль ногдуулахаас гадна дуудлага худалдаанд оролцох 4 удаагийн эрх, Монголбанкнаас цахим талбараар оролцох оролцоонд сонгогдох 2 удаагийн эрхийг хасна.

10.1.3. Банк нь удаа дараа энэ журмын заалтыг зөрчвөл банкны дуудлага худалдаанд оролцох эрхийг бүрмөсөн хасна.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

**ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДААНД  
ОРОЛЦОХ САНАЛЫН МАЯГТ**

.... оны .... сарын .... өдөр

Арилжааны банкны нэр:

Нийт худалдан авахаар санал болгож буй гадаад валютын дүн:

Нийт худалдахаар санал болгож буй гадаад валютын дүн:

1. Гадаад валютыг худалдан авах санал:

Саналын дугаар	Худалдан авах ам.доллар/юанийн хэмжээ	Худалдан авах ханш
1		
2		
3		
4		
5		
Дүн		

2. Гадаад валютыг худалдах санал:

Саналын дугаар	Худалдах ам.доллар/юанийн хэмжээ	Худалдах ханш
1		
2		
3		
4		
5		
Дүн		

НЭГДҮГЭЭР ГАРЫН ҮСЭГ:

ХОЁРДУГААР ГАРЫН ҮСЭГ:

ТАМГА:

ЦАХИМ ШУУДАНГИЙН ХАЯГ:

“Монголбанкны валютын захын оролцооны журам”-ын  
хоёрдугаар хавсралт

**САНАЛ ХҮЛЭЭЛЦСЭН БАРИМТ**

... оны ... сарын ... өдөр

№	Банкны нэр	Хүлээлгэн өгсөн		Хүлээн авсан	
		Ажилтны овог нэр, албан тушаал	Гарын үсэг	Монголбанкны ажилтны гарын үсэг	Цаг минут
1					
2					
3					
4					
5					
6					
...					
...					



“Монголбанкны валютын захын оролцооны журам”-ын  
гуравдугаар хавсралт

**ВАЛЮТ АРИЛЖААНЫ ТӨЛБӨРИЙН БАТАЛГАА**

Харилцагч байгууллагын нэр:			
Арилжааны огноо:			
Монголбанк худалдан авах/худалдах валют:			
Валютын дүн /тоогоор болон үсгээр/			
Арилжааны хэлбэр:			
Валют хүлээн авах данс:			
Төгрөгийн дүн /тоогоор болон үсгээр/			
Төгрөг шилжүүлэх данс:	Банк	Дансны дугаар	Төгрөгийн дүн
Ханш:			
Төлбөр хийгдсэн огноо:			
Харилцагч байгууллагыг төлөөлж /тамга/: /албан тушаал/			
Монголбанкны Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газрын захирлын гарын үсэг			